

**Нийгмийн ажил, сэтгэл зүй****ХОРИГДЛЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ, ЧИГ ХАНДЛАГА****THE ORETICAL PERSPECTIVES, FOUNDATIONS, AND TRENDS IN  
PRISONER REINTEGRATION****П.Баярбаатар**

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны  
сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш,  
доктор (Ph.D), дэд хурандаа*

**Товч утга:** Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа нь нийгмийн ажил, хууль зүй, социологи, сэтгэл судлал зэрэг олон шинжлэх ухааны онол, арга зүйд суурилсан цогц, системтэй үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагаа нь хоригдлыг нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл, хэм хэмжээнд дахин нэгтгэх буюу нийгэмшүүлэхэд чиглэгддэг. Монгол Улсад хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдаж, мэргэжлийн үйлчилгээ хэлбэрээр хэрэгжиж байгаа бөгөөд эцсийн зорилго нь хоригдлыг нийгэмд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хэвийн түвшинд амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

**Түлхүүр үгс:** Хоригдол, хорих байгууллага, сэтгэл зүйн тулгамдсан асуудал, нийгэмших, төлөвшүүлэх.

**Abstract:** The social reintegration of prisoners constitutes a complex and multidisciplinary process, underpinned by theoretical and methodological foundations drawn from social work, legal studies, sociology, and psychology. This process seeks to restore incarcerated individuals to socially accepted norms and values, facilitating their reintegration as constructive members of society. In the context of Mongolia, reintegration efforts are formally regulated within the national legal framework and are implemented through professional, service-based interventions. The ultimate objective of these efforts is not only to prevent

recidivism, but also to support the rehabilitation and social functioning of former inmates, enabling them to lead stable, law-abiding lives post-incarceration.

**Key words:** Prisoner, correctional, psychological issues, socialize, rehabilitate

## УДИРТГАЛ

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс гэмт явдал хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн өмнө байгалийн гамшгаас дутуугүй айн чичирч амь нас, эд хөрөнгөө хамгаалахын тулд төрөл бүрийн оролдлого хийсээр иржээ. “Гэмт явдал нь ил биш далдуур, нууц хэлбэртэй үйлдэгддэг тул нэг талаас судлан дүгнэлт хийхэд маш төвөгтэй үзэгдэл гэж үздэг. Гэмт хэргийн шинж чанар нь хүн төрөлхтөн хамтран амьдарч эхэлснээс хойш оршин тогтнож ирсэн бөгөөд эрх зүйн шаардлага зөрчсөн хүний гэмт үйлдэлд тохирох арга хэмжээ авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж нийгэмд тогтоосон хэм хэмжээг дахин зөрчүүлэхгүй байхад анхаарч ирсэнтэй холбоотой нийгэмшүүлэх гэх асуудал хөгжих суурь тавигдсан байна” (Баярбаатар, 2024).

Нийгмийн нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн ч цаг үеэсээ шалтгаалан гэмт хэргийн оролцогч тал гэх ойлголт байсаар ирсэн төдийгүй, харин харилцан адилгүй байдлаар шийдвэрлэгдэж байжээ. Тухайлбал, “XIII зуунд дэлхийн ихэнх нутаг дэвсгэрт хүн амины хэрэг үйлдэхэд зарим хүн нь загнуулж зэмлүүлэх төдий шийтгэл авч байхад өөр бусад нь толгойгоо авхуулахаас өөр сонголтгүй байжээ. Үүнээс үүдэн XVIII дугаар зууны үеийн криминологийн сонгодог сургаалын тэргүүлэх онолч Ч.Беккариа “Гэмт хэрэг ба ял” бүтээлдээ хууль нь бүгдэд адил тэгш үйлчлэх ёстой бөгөөд тодорхой гэмт хэргийн ялыг хууль тогтоох байгууллагаар стандартчилах ёстой, цаазаар авах ялыг цуцлах, ялыг харгис хэрцгий байлгахыг зогсоож дахин нийгэмд амьдрах боломжийг олгох буюу нийгэмшүүлэх нь зүйтэй” гэж үзжээ. “Энэ үзэл баримтлалтай холбоотойгоор өнөөгийн дэлхий дээрх зарим гэмт хэрэг нь хорих байгууллагад хоригдох замаар эрх чөлөөгөө хасуулан зайлшгүй ял эдлэх ёстой гэм буруутай үйлдэл гэдэг нь нийтлэг болсон төдийгүй гэмт хэрэгтнийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх асуудал хэлбэрээ олж” (Мөнх-Эрдэнэ, 2021, хууд. 38) нийгмийн гажуудал болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дахин гаргуулахгүй байхад анхаарлаа хандуулж эхэлжээ. “Германы эрдэмтэн Л.А.Фейербах, Ф.Ф.Лист нар ялын харьцангуй онолыг үндэслэсэн төдийгүй ял нь дан ганц залхаан цээрлүүлэх бус, харин ялтныг

нийгэмшүүлэх, улмаар урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байдаг ял нь цээрлүүлэх, нийгэмшүүлэх хоёрын аль нэгийг нь орхигдуулахгүй байх замаар ялын зорилгыг хангах боломжгүй” (Мөнхбат, 2020, хууд. 17) гэж үзэж иржээ.

Тэгвэл гэмт хэрэг үйлдсэн хүн нь бусад хүмүүстэй олон талт, системтэй харилцаанд орох явцад үүсэж бий болсон нийгмийн сөрөг шинж чанарыг нэгтгэсэн цогц үйл ажиллагаа бөгөөд танин мэдэхүй, харилцааны субъектийн хувьд зөвхөн засан хүмүүжих буюу нийгэмших боломж бүхий шинж чанараар хязгаарлагддаггүй гэж үздэг эрдэмтэд цөөнгүй байдаг. Өөрөөр хэлбэл, “гэмт хэрэг үйлдсэн хүний нийгмийн шинж чанар нь түүнийг нийгмийн бүлэг, хамтлагийн гишүүн зэрэг нийтлэг шинж чанарынх нь хувьд авч үзэхэд хүргэдэг төдийгүй идэвхтэй, ашигтай нийгмийн харилцаанд оруулах явдал нь түүний нийгэмших буюу нийгмийн хэвийн амьдралд гарахад чухал нөхцөл” (Жанцан, 2000, хууд. 45) бүрддэг гэжээ. Үүнээс үзвэл, хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд нийгмийн шинжлэх ухаан тэр дундаа хууль зүй, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх, нийгмийн ажлын онол, үзэл баримтлалыг үндэс болгон хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

“ОХУ-ын нийгмийн ажлын судлаачдын дунд нийгмийн ажлын онолыг нийгмийн шинжлэх ухааны аль салбарын нөлөө дор оршиж байгаа шинжээр нь ангилах хандлага түгээмэл байдаг. Тухайлбал, И.М Невлева болон Л.В Соловьева нар социологи, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх, хууль зүйн шинжлэх ухаан бол нийгмийн ажилд хамгийн ихээр нөлөөлдөг шинжлэх ухаан юм. Тиймээс хоригдлыг нийгэмшүүлэх онолын сэтгэлгээнд сэтгэл зүйд баримжаалсан, социологид баримжаалсан, цогц шинжид баримжаалсан гэсэн гурван хандлагыг тодорхойлж болох юм” (Лузгин, Кузнецов, & Казанцев, 2005, хууд. 24), “А.Н Вершикова нийгмийн ажлын онолын хандлагыг хувь хүн, бие хүнд баримжаалсан, нийгмийн тогтолцоонд баримжаалсан, нийгмийн үйлдэл үйл ажиллагаанд баримжаалсан” зэрэг түвшинд тулгуурласан байдлаар авч үзсэн боловч онолын хувьд мөн л сэтгэл судлал, социологи болон сурган хүмүүжүүлэх ухаан, хууль зүйн шинжлэх ухааны онол үзэл баримтлалын хүчтэй нөлөөн дор оршдог” (Түмэннаст, 2019, хууд. 89) гэж тэмдэглэжээ.

Ийм ч учир олон улсад хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг тодорхойлж буй байдлыг сонирхон үзвэл:

- “ресоциализация (resocialization) дахин нийгэмшүүлэх гэдэг нь үнэт зүйлс, журмыг үл ойшоон, санаатайгаар зөрчсөн гэм буруутай хүмүүнийг ухааруулан ойлгуулах /ухамсарлуулах/, сөрөг зан байдал, харьцаа, амьдралын хэв маяг, сэтгэхүй, сэтгэлгээг нь өөрчлөн засан төлөвшүүлэх үйл ажиллагаа;

-коррекция, (correction) буюу зан байдал, сэтгэхүй, үг хэллэг, амьдралын гажуудал-эвдрэл, хэв маягийг нь засан өөрчлөх үйл ажиллагаа;

-социальная реабилитация (social rehabilitation) нийгмийн амьдралд хэвшүүлэн оруулах буюу сэтгэц гэм судлал, анагаах ухааны үүднээс эдгээр хүмүүсийн зан байдал, сэтгэл зүйг нөхөн сэргээх, өөрчлөх, өөртөө болон бусдад итгэх итгэлийг нь бий болгох” (Амарсанаа, 2004, хууд. 637);

-“исправительное перевоспитание, (correctional reeducate) гэмт хэрэгтэн, хууль зөрчигчдийг дахин хүмүүжүүлэх” (Амарсанаа, 2004, хууд. 624);

-“социальная работа (social work) буюу дэмжин туслах үйл ажиллагаа;

-“адаптация (adaptation) буюу иргэний, чөлөөт нийгэмд дасан зохицож, хариуцлагаа хүлээн, ухамсарлах, бие даан амьдрах дадал хэвшил, чадварт сургах” (Гантулга, 2015, хууд. 23) гэсэн нэр томъёогоор хэрэглэдэг байна.

Харин академич, боловсрол судлалын шинжлэх ухааны доктор Н.Бэгз “Хүний хөгжил бүтээлдээ нийгэмшлийг 2 үе шатад авч үзсэн байдаг. Нэгдүгээрт төрөхөөс эхлээд өсвөр насыг дуустал явагдах, хоёрдугаарт залуу наснаас ойролцоогоор 20 наснаас эхлэн насан туршдаа явагддаг гэж дурдсан байна. Тэрээр насанд хүрсэн хүний нийгэмшлийг хүн амьдралдаа өөрийгөө таних, байр суурь, үзэл бодолтой болох, ялгаатай бүлгийн соёл, эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрч сурахад чиглэгддэг гэсэн нь хоригдолд нийгэмшил явагдах үйл явц нь хорих байгууллагын зүгээс нийгэмшүүлэх үйл ажиллагааг дамжуулагч буюу зохион байгуулах үүрэгтэйгээр оролцдог”.

Хоригдлын нийгэмшүүлэх асуудал нь хувь хүний онцлог, цаг хугацаа, орчин, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнд явагддаг.

Тодруулбал, хувь хүн талаасаа хоригдлын гэр бүлийн хүмүүжил, төлөвшил, харилцаа, итгэл үнэмшил нөлөөлөх бол нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх хорих байгууллагын хувьд хууль эрх зүйн орчин, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний хүний нөөцийн чадавх, хөрөнгө санхүү, нийгэмшүүлэх хөтөлбөр гэх мэт олон хүчин зүйлийн нөлөө, харилцан үйлчлэл бүхий эрх зүйн зохион байгуулалт юм. Ингэснээрээ хоригдол нийгэмших буюу эрх зүйн ухамсрыг өөртөө суулгах, бусдын үзэл бодол, хандлагыг хүлээн зөвшөөрөх, өөрийн тухай ойлголт, төсөөллийг авч төлөвшдөг байна. Энэ нь нийгэмшлийн хамгийн гол агуулга буюу цөм нь юм.


Дээрхээс дүгнэн үзэхэд хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа нь системчилсэн судалгаа, практикт суурилан сургалт, сэтгэл зүйн нөлөөллөөр дамжуулан нийгэм, бусад хүмүүсийн дунд зохицож амьдрах, ухамсарлуулах зорилго чиглэл бүхий зохион байгуулалтын үр дүн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хорих ял эдэлж буй хүний бусад хүний дунд байх хэрэгцээ, бусад хүнд хэрэгтэй нэгэн байх чадварыг төлөвшүүлэх буюу хоригдлыг нийгэмшүүлэхэд нийгмийн ажлын шинжлэх ухааны онол, үзэл баримтлалд тулгуурласан мэргэжлийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэх нь үр дүнтэй. Учир нь нийгмийн ажлын шинжлэх ухаан нь хүний хөгжил, өөрийн амьдралыг тодорхойлох, шударга ёсыг хангах, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд анхаарал хандуулж ирсэнтэй холбоотой.

Нөгөөтгээгүүр, хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь тэдний хангагдаагүй хэрэгцээг тодорхойлох байдлаар үйл ажиллагаагаа чиглүүлэх учиртай. Энэ нь хоригдлын тухайн үеийн нөхцөл байдал нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хэрэгцээтэйгээ нягт уялдах ба хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь өөрийнх нь нөөц дээр тулгуурлан шийдвэрлэх боломжтойгоор зохион байгуулах талаарх ойлголт юм. “Хэрэгцээ нь тухайн өгөгдсөн нөхцөл байдалд нийгмийн тогтолцоо болон хувь хүний аль алинд нь зайлшгүй хэрэгтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай боломж юм. Хоригдлын хэрэгцээ нь нийгэмшүүлэх ажлын гол өдөөгч гэдгийг дээр дурдсан тул түүнд ач холбогдол өгөхгүй байж болохгүй. Хэрэгцээ нь хүний бодож, хүсэн мөрөөдөж, гачигдаж байгаа мэдрэмж бөгөөд хүний нас, амьдралын нөхцөл байдал зэрэг олон зүйлээс хамаардаг” (Ариунцацрал & Сайханцэцэг, 2012, хууд. 11). Үүнээс үзэхэд, нийгмийн ажлын мэргэжил нь нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжиж, хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг төдийгүй хувь хүн болон нийгэмд байгаа

сайн сайхан зүйлийг хөгжүүлэхэд хүний хүч, эрх, эрх чөлөөг дэмжих явдал юм.

Хоригдлыг нийгэмшүүлэх асуудлыг тодорхойлон авч үзвэл “хорих ял эдэлж эхлэхээс дуусах хүртэл бүхий л хугацаанд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэн, цаашлаад олон улсын байгууллагыг оролцуулах, туслалцаа авах зэргээр хамтын ажиллагааг тогтоосон нь хоригдлыг нийгэмшүүлэх ажилд оролцох цар хүрээг тодорхойлжээ” (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017). Өөрөөр хэлбэл, хоригдлыг ял эдлэх хугацаанд нь нийгэмшүүлснээр шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах өргөн цар хүрээтэй асуудал гэдгийг харуулдаг. Тэгвэл хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь ямар хугацаанд үргэлжлэх ёстой талаарх ойлголт бол шүүхээс оногдуулсан ялын хугацаа юм.

Зураг 1. Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааны судалгаа:



“Тоон мэдээнээс харахад 44.7 хувь буюу 1857 хоригдол нь 0-5 жил, 25 хувь буюу 1040 хоригдол 6-10 жил, 25.4 хувь буюу 1057 хоригдол 11-19 жил, 4.8 хувь буюу 203 хоригдол 20 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн байна. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих байгууллагын зүгээс нийгэмшүүлэх буюу нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн үйлчилгээний үргэлжлэл гэж үзэж болно” (Баярбаатар, 2024, хууд. 29).

Ийнхүү хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд мэргэшсэн нэгжээр дамжуулан онолын үндэслэлтэйгээр буюу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хувь хүний ялгаатай байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлог, ял эдлүүлэх нөхцөл, дэглэм зэрэглэлийг харгалзан үе шаттай ялгамжтай зохион байгуулах бөгөөд хоригдол ял эдлэх хугацаандаа нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох, хууль дээдлэх төлөвшилтэй болгоход чиглэгджээ. Энэхүү зорилгыг хангахын тулд ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн тусгай хөтөлбөрөөр нийгэмшүүлэх ажлыг үе шаттай, ялгамжтай зохион байгуулах, боловсрол эзэмшүүлэх, албадан сургалтад хамруулах хэлбэртэйгээр зааж өгчээ.

“Гэмт хэрэг үйлдсэн бүх хүн, хүн ам зүй, эрх зүй, сэтгэл зүй, харилцааны ур чадвар ба бусад шинжээрээ хоорондоо ялгаатай, нөгөө талаараа хоорондоо төсөөтэй байж, тогтвортой төрлийг бий болгож байдаг. Гэмт хэрэгтний ангилал, төрөл бүрийн үндэслэлээр хийгддэг. Тухайлбал, социологи, эрх зүйн гэсэн хоёр том бүлэг байна” (Болдбаатар, 2010, хууд. 67).

- “социологийн бүлэгт нас, хүйс, боловсрол, гэр бүлтэй эсэх, нийгмийн гарал, ажил хөдөлмөр, эрхлэлт, ажил хөдөлмөрийн төрөл, ямар мэргэжилтэй, оршин суух газар зэрэг;

- эрх зүйн бүлэгт үйлдсэн гэмт хэргийн шинж, төрөл, анх удаа, эсвэл давтан үйлдсэн, ганцаар, бүлгээр үйлдсэн, гэмт үйл ажиллагааны үргэлжилсэн хугацаа, гэмт халдлагын объект, гэм буруугийн хэлбэр.


Дээрх ангиллыг үндэслэн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хор аюулын хэмжээ, гэм буруугийн хэлбэр, сэдэлт, зорилго зэргийг харгалзан дараах байдлаар ангилжээ Үүнд:

- хүч хэрэглэсэн болон танхайн гэмт хэрэг үйлдэгч;
- шунахайн сэдэлтэй гэмт хэрэг үйлдэгч;
- санаатай болон болгоомжгүй гэмт хэрэг үйлдэгч;
- дахин болон байнга гэмт хэрэг үйлдэгч;
- насанд хүрээгүй, дунд насны, идэр насны, хөгшин;
- үйлдсэн гэмт хэргийн ангиллаар нь хүнд, хөнгөн гэмт хэрэг үйлдэгч;

- эрэгтэй, эмэгтэй;

- гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаанаас нь хамааруулж өдөр, өглөө, оройн цагаар гэмт хэрэг үйлдэгсэд” (Зүмбэрэллхам, 2022) гэх мэтээр криминологийн үүднээс ангилсан байдаг нь хоригдлыг нийгэмшүүлэх ажилд голлох нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Зураг 2. Хоригдлын үйлдсэн гэмт хэргийн төрөл:



“Дээрх ял эдлэгчдийн тоон үзүүлэлтээс харахад 1917 буюу 46.1 хувь нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн бол 2497 буюу 55.2 хувь нь дахин гэмт хэрэг үйлдсэн, 4272 буюу 93.8 хувь нь эрэгтэй, 254 буюу 6.1 хувь нь эмэгтэй хоригдол байгаагаас 24.7 хувь нь хүний амьд явах эрхийн эсрэг, 9.3 хувь нь хүний эрүүл мэндийн эсрэг, 24.3 хувь нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 34.8 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн түгээмэл зүйлийг харж болно” (Баярбаатар, 2024).

Хорих ял эдлэгсдийг гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, шүүхээс оногдуулсан ялын хугацаа, эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухааны үүднээс харахад хоригдлыг нийгэмшүүлэх ажил нь онол, үзэл баримтлалд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй, бусад шинжлэх ухаантай уялдаатайгаар хөгжүүлэх нийгмийн хэрэгцээтэй төдийгүй хоригдлын хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлогт тохирсон, тусгайлсан хөтөлбөрөөр дамжин хэрэгжих нь зүйтэй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн салбарын зарим эрдэмтэн, судлаачдын хувьд “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхийн шийтгэх тогтоолд заасан тодорхой хугацаанд нийгмээс тусгаарлах төрийн албадлагын хэм хэмжээ нь тусгай орчин нөхцөлд сургах, мэргэжил эзэмшүүлэх, хүмүүжлийн нөлөөлөл, тусламж дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрлүүлэх хэлбэрээр нийгэмшүүлснээр дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх, хууль ёсыг хүндэтгэн сахидаг, үнэнч шударга иргэн болгох



зорилгыг агуулсан байдаг” (Дашзэвэг, 1976, хууд. 19), (Сэрсэнжав, 2001, хууд. 4) гэж үзсэн зэргээс харахад хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааг нийгмийн ажлын онолын үзэл баримтлалд тулгуурлан хөгжүүлэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чухал нөлөө үзүүлэх учиртай

### ДҮГНЭЛТ

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны онол, үзэл баримтлал, чиг хандлага сэдвийн хүрээнд онол, мөн чанар, онцлог, хоригдлыг нийгэмшүүлж ирсэн эрх зүйн зохицуулалтыг уламжлалыг судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. “Нийгмийн ажил нь нийгмийн бүлэг, хувь хүний хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг үзүүлэх хүрээнд бусад шинжлэх ухаан, тухайлбал, хууль зүй, социологи, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, нийгмийн халамж, эрүүл мэндийн зэрэг олон салбартай нягт уялдан хөгжиж ирсэн байна. Үүнтэй уялдан хоригдлыг нийгэмшүүлэх асуудлыг нийгмийн ажлын ерөнхий шинжлэх ухааны онол, үзэл баримтлал дээр тулгуурлан, эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, криминологи, социологийн онол, арга зүйг өргөнөөр ашиглан хөгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2. Хоригдлыг нийгэмшүүлэх нь улс орны нийгэм, эдийн засаг, аюулгүй байдал, эрх зүйн шаардлагаас урган гарсан, иргэний, хүмүүнлэг нийгэм цогцлоон хөгжүүлэх хөгжлийн бодлоготой уялдсан байна. Монгол Улсын тухайд Үндсэн хууль, Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх асуудал хуульчлагдан баталгаажиг өгчээ. Иймд хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажил нь ял эдлэх төрөл, дэглэм, зэрэглэл, хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлог зэргээс үл хамааран сургалт, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгэмтэй холбон зуучлах хэлбэрээр хэрэгждэг эцсийн зорилго нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн цогц үйл ажиллагаа юм.

3. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажил нь хорих ангид хоригдлыг хүлээн авахаас эхлээд суллагдах хүртэлх бүх цаг хугацааг хамарсан байх ба энэ үйл ажиллагаа нь мэргэжлийн үйлчилгээ хэлбэрээр хэрэгждэг байна. Өөрөр хэлбэл, хүн төрөлхтний түүхэнд бие биедээ туслан дэмжих асуудал эрт үеэс үүсэлтэй хэдий ч нийгмийн ажлын шинжлэх

ухаан 100 гаруй жилийн өмнө үүссэн ба манай оронд 20 гаран жилийн өмнө буюу харьцангуй сүүлд хөгжсөн ч хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлалд сургах, хүмүүжүүлэх зэрэг асуудал 100 гаруй жилийн өмнө байсан тул уламжлалт үйл ажиллагааг орхигдуулахгүй, шинэчлэлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн онолын суурьтай хөгжүүлэх нь зүйтэй байна” (Баярбаатар, 2024).

#### Эх сурвалж

Амарсанаа, Ж. (2004). Англи-Орос-Герман-Монгол олон улсын эрх зүйн толь. Улаанбаатар.

Ариунцацрал, М., & Сайханцэцэг, Л. (2012). Нийгмийн ажлын онол, арга зүйн үндэс. Улаанбаатар.

Баярбаатар, П. (2024). Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт. Улаанбаатар.

Баярмаа, Б., & Мэргэнбаяр, У. (2006). Нийгмийн ажил. Улаанбаатар.

Болдбаатар, Ж. (2010). Криминологи. Улаанбаатар.

Гантулга, Н. (2015). Ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх ажиллагаа дахь хамтын оролцоо. Хууль сахиулахуй сэтгүүл /тусгай дэвтэр/.

Дашзэвэг, Б. (1976). Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн сурган хүмүүжүүлэх зүй. Улаанбаатар.

Жанцан, Н. (2000). Криминологи. Улаанбаатар.

Зүмбэрэлхам, Д. (2022). Криминологийн онол. Улаанбаатар.

Лузгин, С., Кузнецов, М., & Казанцев, В. (2005). Хорих байгууллагын нийгмийн ажил. Рязань.

Мөнхбат, Ц. (2020). Нийтэд тустай ажил хийлгэх ял. Улаанбаатар.

Мөнх-Эрдэнэ, Б. (2021). Гэмт хэрэг судлалын онол. Улаанбаатар.

Сэрсэнжав, Ю. (2001). Засан хүмүүжүүлэхүй. Улаанбаатар.

Түмэннаст, Г. (2019). Нийгмийн ажил. Улаанбаатар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, №24 (Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 оны 6 9).